



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/688

Булган сум

**Жуулчны хөтөч тайлбарлагч бэлтгэх
сургалтын зардалд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.13 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх соёлын орон зайд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Жуулчны хөтөч, тайлбарлагч бэлтгэх” сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Жуулчны хөтөч, тайлбарлагч бэлтгэх сургалтыг шинэлэг, бүтээлч байдлаар зохион байгуулахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д даалгасугай.

3.Зохион байгуулалтад шаардагдах 6,900,000 (зургаан сая есөн зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталж, Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах, хөгжүүлэх, сурталчлан таниулах” төсөл, арга хэмжээний зардлаас 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулахыг сангийн нягтлан бодогч Э.Эрдэнэжаргал, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх” төсөл, арга хэмжээний зардлаас 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010977

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 29-ны/ний өдрийн
А/688 дугаар захирамжийн хавсралт

Жуулчны хөтөч, тайлбарлагч бэлтгэх сургалтын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1	2	3	4	5
1	Сургалтад оролцогчдын цайны зардал	30	10,000	300,000
2	Багш нарын сургалтын төлбөр	4	1,350,000	5,400,000
3	Багш нарын буудлын зардал	2	180,000*2	720,000
4	Багш нарын хоолны зардал	4	60,000*2	480,000
Нийт зардал			6,900,000	